

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв”
ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/08-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Утас: 99158257 Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын санал дүгнэлт



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН
“ЭРДЭНЭМАНДАЛ ШИЛМЭЛ СҮРГИЙН
ҮРЖЛИЙН ТӨВ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д. ТҮВШИНСАЙХАН ТАНАА

2023.03.15 № 126

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ нь 2022 онд түрээсийн болон мал худалдан авах, худалдах гэрээний дагуу төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, гэрээний дүнгээс 3,220.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.
- Хуулийн этгээд нь 2022 оны бизнес төлөвлөгөөг дүрмийн 8.2 дахь заалтын дагуу боловсруулан батлуулж тайлант жилийн орлого, зардал, ашиг алдагдлыг тооцоолоогүй байна.
- Хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Төрийн жинхэнэ албан хаагч буюу сумын ЗДТГ-ын даргыг томилон ажиллуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн, бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс дээгүүр бөгөөд аудитын тохиолдсон байх, үнэлгээ

ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.00	ХӨРӨНГӨ		
1.10	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,238,400.00	2,796,160.50
1.1.6	Бараа материал	-	400,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө мал амьтад	-	108,970,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,238,400.00	112,166,160.50
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,238,400.00	112,166,160.50
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.10	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	66,450.55
2.1.1.3	Татварын өр	-	66,450.55
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	66,450.55
2.20	Өр төлбөрийн нийт дүн	-	66,450.55
	Эздийн өмч		
2.30	Өмч :		
2.3.1	а) төрийн		108,970,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,238,400.00	3,129,709.95
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,238,400.00	112,099,709.95
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,238,400.00	112,166,160.50

/төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	Борлуулалтын орлого (цэвэр)		10,080,000.00
2	Борлуулалтын өртөг		-
3	Нийт ашиг (алдагдал)	-	10,080,000.00
4	Түрээсийн орлого	3,350,000.00	
7	Хандив тусламжийн орлого		13,600,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,111,600.00	21,769,585.91
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,238,400.00	1,910,414.09
19	Орлогын татварын зардал	-	19,104.14
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,238,400.00	1,891,309.95
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,238,400.00	1,891,309.95
24	Орлогын нийт дүн	1,238,400.00	1,891,309.95

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.00	1,238,400.00	1,238,400.00
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.00	1,238,400.00	1,238,400.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	1,891,309.95	1,891,309.95

Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

14	Өмчид гарсан өөрчлөлт	108,970,000.00	0.00	108,970,000.00
17	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	108,970,000.00	3,129,709.95	112,099,709.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,350,000.00	23,680,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,350,000.00	10,080,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	13,600,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,111,600.00	22,122,239.50
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	14,241,171.43
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	3,589,428.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	265,600.00	1,966,000.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	1,592,415.07
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	687,625.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,846,000.00	45,600.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,238,400.00	1,557,760.50
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,238,400.00	1,557,760.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,238,400.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,238,400.00	2,796,160.50

2.5 Аудит хийсэн батлагдсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Цалин, урамшуулал	17,400.0	14,241.2	3,158.8
2	НДШ	2,175.0	3,589.4	(1,414.4)
3	Татвар	1,059.9	687.6	372.3
4	Өвс тэжээл худалдан авах	1,000.0	1,030.0	(30.0)
5	Малд үзлэг ангилалт хийх	500.0	0.0	500.0
6	Мал эмнэлэгийн зардал	1,000.0	368.0	632.0
7	Тээвэр шатахуун	2,500.0	1,592.4	907.6
8	Бичиг хэрэг	100.0	67.0	33.0
9	Малын тоо толгойн албан татвар	165.0	0.0	165.0
10	Бараа үйлчилгээний бусад зардал		501.0	(501.0)
11	Банкны шимтгэл		45.6	(45.6)
	Нийт зарлагын төсөв	25,899.9	22,122.2	3,777.7

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар 19,664.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрч залруулга хийгдлээ. Залруулагдаагүй 4,070.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнээс 3,220.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 850.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, мөн 2 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Залруулсан алдаа

Аудитаар 19,664.5 мянган төгрөгийн дараах алдаа зөрчлийг залруулсан Үүнд:

Тус үйлдвэрийн газрын нягтлан бодогч нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 19,664.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан гэж тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

3.2 Төлбөрийн акт

3.2.1. Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ нь хээлтүүлэгч мал түрээслүүлэх гэрээний дагуу нийт 12,400.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс тайлант онд 9,180.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,220.0 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, гэрээний 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрийн газрын төсөвт дутуу орлогыг төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.3 Албан шаардлага

3.3.1. Малчин С.Баасанжавд худалдан борлуулсан хуцны төлбөр 850.0 мянган төгрөг Мал худалдах, худалдан авах гэрээний дагуу он дамжин төлөгдсөн бөгөөд авлагыг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дэхь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.3.2 Эрдэнэмандал сумын ИТХТ-ийн 2021.09.13-ны өдрийн 18 дугаар тогтоолоор "Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сумын ЗДТГ-ын дарга З.Батмөнхийг томилж ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.17-д "үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг таслан зогсоож, үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх албан шаардлагыг сумын ИТХ-ын даргад хүргүүлэв.

3.3.3 Тайлант онд 23,680.0 мянган төгрөгийн орлого олж үйл ажиллагаанд зарцуулсан бөгөөд нийт эх үүсвэрийн 57.4 хувь буюу 13,600.0 мянган төгрөгийг сумын ОНХС-ийн дэмжлэгээр бий болгосон, мөн тус газрын дүрмийн 11.1 "Үржлийн төвийн орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ" гэсний 11.1.1 "Орон нутаг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сан болон бусад төсвийн санхүүжилт" гэж баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7 "Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй" гэсний 4.7.6 "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал". Өөрөөр хэлбэл ОНХС-ийн журмыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.3.4 Хуулийн этгээд нь 2022 оны үйл ажиллагааны зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг дүрмийн 8.2 дахь заалтын дагуу боловсруулан батлуулаагүй, тайлант жилийн орлого, зардал, ашиг алдагдлыг тооцоолоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.Захирал дараахь эрх, үүрэгтэй гэсний 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах, байгууллагын дүрмийн 8. Үржлийн төвийн захирлын эрх үүрэг гэсний 8.2-т "Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид үйл ажиллагааны зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг боловсруулан сумын ИТХ-аар батлуулах албан шаардлага хүргүүлэх

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аудитаар тус үйлдвэрийн газар нь шилэн дансны цахим хуудасгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын дагуу шилэн дансны цахим хуудас нээлгэх, мэдээллийн хуулийн хугацаанд тогтмол байршуулж ажиллах

2. Ногдол ашигтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангийн жилд 1,891.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба сумын орон нутгийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх холбогдох шийдвэрийг гаргуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай, Татварын тухай хуулийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас ногдол ашгийн хэмжээг тооцож, сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ	1	19,664.5			1	19,664.5	1	19,664.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ	7	4,070.0	1	3,220.0	4	850.0	2	0.0	-	-	-	-

